

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/001/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2026.03.25 № 339
танай _____ ны № _____ т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийгмийн даатгалын төв сангаас 122,098.81 сая төгрөг, улсын төсвөөс 23,495.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 41,110.41 сая төгрөгийг төвлөрүүлж, 122,098.81 сая төгрөгийг зарцуулахаар тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант оны нийгмийн даатгалын сангийн төсвийг нийгмийн даатгалын сангаас 122,098.81 сая төгрөг, улсын төсвөөс 23,495.21 сая нийт 145,594.02 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нийт 5 удаа тодотгол хийжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас нийгмийн даатгалын төв сангаас 94,265.1 сая төгрөг, улсын төсвөөс 24,352.3 сая төгрөг, нийт 118,617.4 сая

6326050522

төгрөгийн санхүүжилт, ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 45,032 сая төгрөгийг бүрдүүлж тус дүнгээр төвлөрүүлсэн байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өссөн, Засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан зэргээс шалтгаалан нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

АДБОУС 2706. 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,645,828.68	11,278,197.04
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	0	0
	Нийт хөрөнгийн дүн	11,645,828.68	11,278,197.04
	Нийт өр төлбөрийн дүн	984,226.00	1,882,571.59
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,661,602.68	9,395,625.46
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,645,828.68	11,278,197.04
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	137,845,287.44	155,803,989.35
	Үйл ажиллагааны зардлын дүн	136,489,010.15	157,120,457.24
	Үйл ажиллагааны үр дүн	1,356,277.29	-1,316,467.89
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,356,277.29	-1,316,467.89
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,305,325.39	10,712,093.34
	Тайлант оны үр дүн	0	-1,316,467.89
	Эцсийн үлдэгдэл	10,661,602.68	9,395,625.46
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	144,196,430.91	163,796,366.37
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	142,589,581.54	164,147,541.67
	Үйл ажиллагааны ЦМГ	1,606,849.37	-351,175.31
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,606,849.37	-351,175.31
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,422,018.91	10,028,868.28
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,028,868.28	9,677,692.97
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	119,581,073.60	119,111,249.66
	Урсгал зардал	119,581,073.60	119,111,249.66
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		145,594,010.00
	Улсын төсвөөс санхүүжих		23,495,200.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		122,098,810.00

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын сан нь Даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх зорилготой сан юм.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах, нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх, Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, тэтгэврийн даатгалд хамруулах, төлсөн шимтгэлийг бүртгэх, тэтгэврийн даатгалын сан бүрдүүлэх, төвлөрүүлэх, шимтгэлийн буцаан олголтыг холбогдох журмын дагуу тус тус зохион байгуулж ажилладаг.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийгмийн даатгалын төв сангаас 122,098.81 сая төгрөг, улсын төсвөөс 23,495.2 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 41,110.41 сая төгрөгийг төвлөрүүлж, 122,098.81 сая төгрөгийг зарцуулахаар тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант оны нийгмийн даатгалын сангийн төсвийг нийгмийн даатгалын сангаас 122,098.81 сая төгрөг, улсын төсвөөс 23,495.21 сая нийт 145,594.02 сая төгрөгөөр баталсан байна. Тайлант онд нийт 5 удаа тодотгол хийжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас нийгмийн даатгалын төв сангаас 94,265.1 сая төгрөг, улсын төсвөөс 24,352.3 сая төгрөг, нийт 118,617.4 сая төгрөгийн санхүүжилт, ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 45,032 сая төгрөгийг бүрдүүлж тус дүнгээр төвлөрүүлсэн байна.

Тав. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон бусад холбогдох хууль журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын төлөвлөгөөг бүрэн, үнэн зөв төлөвлөх батлах, өглөг авлагыг 20 хувиас багагүйгээр барагдуулж авлага өглөг үүсгэхгүй байх.

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39,281.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 39,281.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

8.1 Төлбөрийн акт

8.2 Албан шаардлага бичигдээгүй.

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нийгмийн даатгалын сангийн авлага холбоотой.

Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын сангийн өмнөх жилүүдийн он дамнасан НДШ-тэй холбоотой 150.8 сая төгрөгийн авлага байгаа боловч авлагыг барагдуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрлөж ажиллах. Зөвлөмжийн дагуу 150.8 сая төгрөгийн авлагын 15 хувиас багагүй хувийг барагдуулж ажиллах.

2. Нийгмийн даатгалын сангийн өглөг холбоотой.

Илрүүлэлт:

Өмнөх жилүүдийн он дамнасан болон тайлант онд үүссэн НДШ-тэй холбоотой 83.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрлөж ажиллах. Зөвлөмжийн дагуу 83.3 сая төгрөгийн өглөгийн 20 хувиас багагүй хувийг барагдуулж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын сангийн өмнөх жилүүдийн он дамнасан НДШ-тэй холбоотой 150.8 сая төгрөгийн авлага байгаа боловч авлагыг барагдуулаагүй.	1	22,620.7					1	22,620.7				
Өмнөх жилүүдийн он дамнасан болон тайлант онд үүссэн НДШ-тэй холбоотой 83.3 сая төгрөгийн өглөгийг барагдуулж ажиллаагүй.	1	16,660.8					1	16,660.8				
Дүн	2	39,281.5					2	39,281.5				